



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/178

Сүхбаатар сум

Тариалангийн газар хамгаалалтын ойн зурвас байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "б", 29.1.6 "а", 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2, 16.2.4, 16.2.10, Тариалангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 25 дугаар зүйлийн 25.1.3, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.2.2, 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах, хөрсийг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалах, хүний болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр доройтохоос сэргийлэх зорилгоор аймгийн нийт газар нутгийн хэмжээнд тариалангийн газар хамгаалалтын ойн зурвас байгуулсугай.

2.Тариалангийн газрын хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг тариалан эрхэлж буй бүх ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлж хэрэгжилтийг хангуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Захирамжийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч, явц үр дүнгийн талаар Засаг даргын зөвлөлд улирал бүр танилцуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Түвшинтөгс/ нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ШОРГИЛ

